

**➤ Шанхайн хотын
худалдааны чөлөөт бүс
хөгжлийн тухай сэдэв**



Гол агуулга

1. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС ГЭЖ ЮУ ВЭ ?
2. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ ШАЛТГААН ?
3. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС ЯМАР АГУУЛГАТАЙ ВЭ ?
4. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС ЮУГ АВЧИРЧ БОЛОХ ВЭ ?
5. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ИРЭЭДҮЙ ?

1. ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС ГЭЖ ЮУ ВЭ ?

- Шанхайн худалдааны чөлөөт бүсийг судлахын өмнө эхлээд гаалийн татваргүй бүсийн талаархи мэдээллийг ойлгох хэрэгтэй



- Өмнө нь гаалийн татваргүй бүс байхгүй байсан бөгөөд бараа бүтээгдэхүүнийг хил гаалиар нэвтэрвэл гаалийн татвар төлдөг байсан.



Хятадын анхны гаалийн татваргүй бүс: Вай Гао Чиао гаалийн бүс



1990 оны 4-р сарын 18-ны өдөр ХКН-ын төв хороо, төрийн зөвлөлөөс Пүдунг нээлттэй хөгжүүлэхийг зарлаж Пүдунг нээх, Шанхайг хөгжүүлэх, улсад үйлчлэх, дэлхийд хандсан чиглэл гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлж мөн тухайн оны 6-р сард төрийн зөвлөлийн зөвшөөрлөөр Вай Гао Чиао гаалийн татваргүй бүсийг байгуулав.

гаалийн татваргүй бүс гэж юу вэ?

Гаалийн татваргүй бүс (tariff-free zone) түүнчлэн гаалийн татваргүй агуулах бүс гэж нэрлэдэг, гаалиар батлагдан бүртгүүлж гаалийн хяналтын дор урт хугацаанд бараа бүтээгдэхүүнийг хадгалах бүсийг хэлж байна. Энэ бол төрийн зөвлөлөөр батлагдан байгуулсан, гаалиас тусгайлан хянадаг эдийн засгийн бүс, манай улсын одоо хүртэл нээлттэй, чөлөөтэй түвшин хамгийн өндөр эдийн засгийн бүс юм.

Гаалийн татваргүй бүсийн үндсэн гурван үүрэг: “баталгаат агуулах, экспортын баримжаатай боловсруулалт, дамжин өнгөрөх худалдаа”. Гаалийн татваргүй бүс экспорт-импортын боловсруулалт, олон улсын худалдаа, гаалийн татваргүй агуулах, бүтээгдэхүүний үзэсгэлэн зэрэг үүрэгтэй, “гэрчилгээгүй, татвараас чөлөөлөх, гаалийн татваргүй бүс” зэрэг бодлогын дэмжлэгтэй, “хилийн дотор, гаалийн гадна” үйл ажиллагааны хэлбэртэй, Хятад улс гадаадад нээлттэй түвшин хамгийн өндөр, үйл ажиллагааны механизм хамгийн уян хатан, бодлого нь хамгийн их хөнгөлөлттэй дэмжлэгтэй эдийн засгийн бүсүүдийн нэг мөн.



- Гаалийн татваргүй бүсийн дотор бараа бүтээгдэхүүнд татвар ноогдохгүй
- Зогсолт хийсний дараа хилрүү нэвтэрхэд татвар төлөх ёстой
- Зогсолт хийсний дахин хилээс гарахад татвар төлөхгүй

- Чөлөөт худалдааны бүс бий болохын өмнө баталгаат бүс бол дотоодод хамгийн нээлттэй газар юм аа

Баталгаат бүсийн ОНЦЛОГ

- Баталгаат бүсийн дотор гаалийн татварын хөнгөлөлт,чөлөөлөлт болон бусад татварын хөнгөлөлтийн бодлоготой.
- Баталгаат бүс,хилийн гаднахын хооронд бараа бүтээгдэхүүнийг чөлөөтэй нэвтрүүлж болно.гаалийн татвар,импортын татвараас чөлөөлдөг.зөвшөөрлийн бичиг шалгахгүй,энгийн гаалийн хяналтаас чөлөөлдөг.
- Баталгаат бүс бол дамжин өнгөрөх худалдаа,баталгаат агуулах,экспортын баримжаатай боловсруулалт зэрэг гадаадад чиглэсэн эдийн засгийг голчлон хөгжүүлэхээр байгуулсан эдийн засгийн тусгай бүс юм.

Вэй Гао Чиао баталгаат бүс улсын хэмжээнд анхных, мөн одоогийн 15 улсын баталгаат

бүсүүдийн доторх эдийн засгийн хэмжээгээр хамгийн том баталгаат бүс. Вэй Гао Чиао баталгаат бүс батлагдахад 10 квадрат километрын талбайг төлөвлөж Шахайн Пүдун шинэ дүүрэгт байрладаг, хөх мөрний далайд цутгах аманд ойрхон, алтан усан зам болон алтан эргийн шугамын уулзварт байршиж Вэй Гао Чиао гүн усан боомт бүсэд ойр, улсын хэмжээнд анхны “улсын импортын худалдааг хөгжүүлэх инновацийн загварын бүс” бөгөөд Шанхайн олон улсын далайн тээвэр, худалдааны төвийн гол суурь үндэс юм.

2010 он Вэй Гао Чиао баталгаат бүс Английн Лондон «санхүүгийн таймс» -аас гаргасан найман хүчин зүйлүүдээр шалгаруулсан дэлхийн чөлөөт худалдааны бүсийн нэгдсэн жагсаалтад нэгдүгээр байр эзэлсэн.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд Шанхайн Вэй Гао Чиао, Тианжин боомт, ШэнЗэн Фү Тиан, Шан Тө булан, Иантиан боомт, Далиан, ГуанЗөн, ЗанЖиа боомт, ХайКө, ШианМэн Шиан-Ну, ФүЗө, НинБо, Чиндао, ШанТө, ЗуХай зэрэг 15 баталгаат бүстэй, харьяалагдаж байгаа байгууллага Гаалийн ерөнхий газар.

Баталгаат бүсэд юу хийж болох вэ?

- Бараа бүтээгдэхүүн баталгаат бүсийн дотор саатах хугацаанд олон юм хийж болно



Чөлөөт худалдааны бүс гэж юу вэ?

Чөлөөт худалдааны бүс (Free Trade Area)

1. Олон улсын хэлэлцээрийн талаас тодорхойлогдсон чөлөөт худалдааны бүс

Чөлөөт худалдааны бүс гэж хоёр эсвэл хоёроос дээш улс орнууд аль нэг гэрээ хэлэлцээр байгуулж гаалийн татвар болон гаалийн татвартай адил хүчинтэй бусад арга хэмжээнээс харилцан чөлөөлсөн олон улсын эдийн засгийн интеграцийн байгуулагыг хэлнэ. Жишээлбэл Хятад, Япон, Солонгосын чөлөөт худалдааны бүс.

2. Гадаад худалдааны талаас тодорхойлогдсон чөлөөт худалдааны бүс

Чөлөөт худалдааны бүс гэж бүрэн эрхт улс орон эсвэл бүс нутгийн гаалийн хилийн гадна тусгайлан тогтоогдсон, гадаадын бараа бүтээгдэхүүнийг гаалийн татвар төлөлгүй чөлөөтэй орон гарч болох бүсийг хэлнэ. Жишээлбэл Хятадын (Шанхай) чөлөөт худалдааны бүс.

Үндсэн нэр томьёо

Чөлөөт худалдааны парк бүс гэж гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд бараа бүтээгдэхүүний хяналт, гадаад валютын менежмент, татварын бодлого, компанийн үүсгэлт зэрэг салбарт тусгай эдийн засгийн зохицуулах механизм, тусгай бодлого хэрэгжүүлж байгаа аль нэг улсын эсвэл бүс нутгийн тусгай бүсийг хэлнэ. Үүнд чөлөөт боомт, чөлөөт эдийн засгийн бүс, гадаад худалдааны бүс гэх мэт орно.

Одоо байгаа чөлөөт худалдааны бүс: Америк тивийн чөлөөт худалдааны бүс, Европын холбоо, Мексикийн чөлөөт худалдааны бүс, Хятад, Япон, Солонгосын чөлөөт худалдааны бүс, Ази номхон далайн чөлөөт худалдааны бүс гэх мэт.

Үндсэн онцлог

улсын үйлдэл, хилийн дотор, гаалийн гадна.

анхан шатанд нээлттэй, хоёрдугаар шатанд зохицуулан удирдах, бүсийн дотор чөлөөтэй, тодорхой үүрэгтэй, өндөр түвшний чөлөөтэй. Энэ бол дэлхийн улс орнууд дэлхийн хэмжээнд үйлдвэрлэлийн хүчин зүйл төвлөрүүлэх, дэлхийн эдийн засгийн төрөлжүүлэлт, өрсөлдөөнд оролцох, эдийн засгийн хөгжлийг бэхжүүлэх чухал зөөгүүр.

- Үүнээс гадна чөлөөт худалдааны бүсийг ойлгоход анхан шат болон хоёрдугаар шат гэдэг нэр томъёотой, зөвхөн газар зүйн байршлаас ойлгож болохгүй



- Анхан шатанд дэс дараалан бүрэн нээлттэй болох
- Хоёрдугаар шатанд аюулгүй, өндөр чадамжтэй зохицуулан удирдах
- Бүсийн дотор чөлөөтэй эргэх

Анхан шат гэж улсын хилийг хэлнэ, хоёрдугаар шат гэж дотоодын зах зээлийн хил заагийг хэлнэ. Өөрөөр хэлбэл чөлөөт худалдааны орон зайны зааг байгаа юм. Анхан шатанд нээлттэй, хоёрдугаар шатанд зохицуулан удирдах гэдэг нь одоо дотоодын бүх баталгаат бүсээс чөлөөт худалдааны бүс болон хөгжих гол арга зам юм.



- Жич:чөлөөт худалдааны бүс бий болсны драа баталгаат бүс хэвээрээ байгаа.Жишээ:Хятад,Япон,Солонгосын чөлөөт худалдааны бүс байгуулсны дараа Хятад,Япон,Солонгос улс хэвээрээ байгаатай адил

- Бодлогын хувьд чөлөөт худалдааны бүс бол одоогийн баталгаат бүсийн бүх талын ахисны үр дүн.Газар зүйн байршлын хувьд чөлөөт худалдааны бүс бол одоогийн баталгаат бүсийн нэгдэл юм.

- Шанхайн чөлөөт худалдааны бүс нь Ианшан баталгаат боомт бүс,Вэй Гао Чиао баталгаат бүс (Вэй Гао Чиао баталгаат ложистик терминал мөн орсон байгаа) ,Пүдун нисэх буудлын баталгаат нэгдсэн бүсээс бүрдсэн байгаа.28 квадрат километрын талбайтай.



Үндсэн илэрхийлэл

“гурван чөлөөтэй”

- 1、 **бараа бүтээгдэхүүн орж гарахад чөлөөтэй:** олон улсын заншилд нийцсэн бараа бүтээгдэхүүн орж гарахад ямар ч саадгүй, гаалийн ердийн шалгалтаас чөлөөлөх.
- 2、 **хөрөнгө оруулахад чөлөөтэй:** улс орнуудын ялгаанаас шалтгаалан хөрөнгө оруулалтад салбарын эсвэл үйл ажиллагааны хэлбэрийн хязгаар тавихгүй.
- 3、 **санхүүгийн чөлөө:** гадаад валют чөлөөтэй хөрвөх, хөрөнгийн чөлөөтэй орж гарах, хөрвөх.

- Баталгаат бүстэй харьцуулвал чөлөөт худалдааны бүсийн бодлогын төсөөлөл илүү нээлттэй



Чөлөөт худалдааны үнэн чанар: орж гарах бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг бууруулах, экс-импортын бараа бүтээгдэхүүний бага гаалийн татвартай холбогдуулан тогтоосон санхүү, үйлчилгээ, худалдаа, ложистик, хууль журам зэрэг.

хоёр, чөлөөт худалдааны бүс байгуулах учир шалтгаан

- Олон улсын худалдааны шинэ нөхцөл байдалд нийцүүлэн Шанхайн чөлөөт худалдааны бүс байгуулав



Ойрын жилүүдэд дэлхийн эдийн засгийн нөхцөл их өөрчлөгдөж байгаа

Америк улс бол гол тоглогч.

◆ 2007 онд Америкийн үл хөдлөх хөрөнгийн зээлийн хямрал гарсан нь

Америкийн холбооны нөөцийн банкнаас дөрвөн удаа QE бодлого гаргаж нийтдээ 2500 тэрбум ам.доллар гаргав.



Америкийн холбооны нөөцийн банк QE бодлогоор дамжуулан зах зээлд их хэмжээний ам.доллар нийлүүлэв.



Америкийн эдийн засаг шат дараалан хямралаас гарав.



Түүний зэрэгцээ Америкаас бусад улс орон их хохирол амссан байна !

Америкийн засгийн газрын үнэт цаас дахин худалдан авч болохгүй



Америкийн үйлдэл бусад улс орныг хулгайлав.

◆ 2010 онд Грекийн өрийн хямрал гарсан нь



Грекийн ерөнхий сайд
Пападемос



Нэгдүгээр.Бидэнд өр дарах мөнгө байхгүй.



Хоёрдугаар.Та нар заавал надад зээл үргэлжлүүлэн олгох хэрэгтэй.



Гуравдугаар.Бид дараа зээл төлье гэвэл ч өрийн хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх шаардлагатай.




Эцэст нь хэрэв бидний шаардлагыг хүлээн авахгүй бол бид Евро бүсээс гарах болно.

Грекийн үйлдэл нь зээлдүүлэгч улс орныг луйвардав.

Ямар сахилгагүй юм бэ



Үйлдвэрлэлийн индекс 2008 оны 2-р сараас 2013 оны 2-р сар хүртэлх өөрчлөлтийн хувь



Эх үүсвэр: Америкийн холбооны нөөцийн банк, худалдаа эдийн засгийн вэб сайт, Европын статистикийн газар, Японы эдийн засаг, үйлдвэрлэлийн яамны тоо баримтыг үндэслэн тооцов.

Аль эрт 2008 онд Америк улс ТРР-д элсэн орсныг зарлаж түүнээс хойш энэ байгууллагын удирдагч болсон юм.

➤ ТРР (Trans-Pacific Partnership Agreement) -ны бүтэн нэр нь номхон далай дамнасан түншлэлийн харилцааны хэлэлцээр. Энэ байгууллагын гол зорилго нь гишүүн улс орнуудын хооронд супер чөлөөт худалдааны бүсийг байгуулахад оршино. Энэ байгууллагад БНХАУ ороогүй.



Үүнийг залгаад энэ жилд Америк улс,Европын холбоо мөн ТТИР хэлэлцээг эхлүүлэв.



Америк улс,Европын холбоо дэлхийн хамгийн том чөлөөт худалдааны бүсийг байгуулахыг төлөвлөж байгаа.Мэдээж хэрэг,үүнд ч БНХАУ-ыг багтаахгүй.

БНХАУ-ын өмнө хүнд сорил бэрхшээл тулгарч байна



15

ТТИР (Transatlantic Trade and Investment Partnership)гэдэг нь атлант далай дамнасан худалдаа,хөрөнгө оруулалтын түншлэлийн харилцааны хэлэлцээр

Энэ хоёр супер чөлөөт худалдааны бүс
Хятадыг шууд шахаанд оруулав.

Хятадыг түр
оруулахгүй шүү



Яагаад Шанхайд чөлөөт худалдааны бүсийг байгуулах вэ?


- Тийм учраас Шанхайн чөлөөт худалдааны бүс давах гарц болох чухал үүрэг хүлээж байгаа, шинэ нөхцөл орчинд олон улсын худалдаанд дасан зохицоно.



- Шанхай газар зүйн байршлын онцгой давуу талтай.
- Санхүүгийн хатуу зүйлийн сайн боломжтой.
- Төрийн бодлогын ихээхэн дэмжлэг авсан байгаа.

Чөлөөт худалдааны бүс Шанхайд
байгаа ч эх улсад зориулагдаж байгаа.

Гурав.Чөлөөт худалдааны бүсээр юу хийх санаатай вэ



Нийтлэг зорилго

Гурваас таван жилийн хүчин чармайлтаар Хятадын Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийг дараахь байдлаар байгуулна: олон улсын түвшинд хүрсэн, тэргүүлэх үүргийн инновацитай, үйлчилгээний худалдааг хангалттай хөгжүүлсэн, худалдаа, хөрөнгө оруулалт хийхэд хөнгөлөлттэй, валютыг чөлөөтэй солилцдог, оффшорын үйл ажиллагаа сайн хөгжсэн, өндөр чадамжтай хяналттай, толгой компани төвлөрөн суурьшсан, хууль эрх зүйн орчин сайн, захиргааны бүтээмж өндөр, ил тод ажиллах зэрэг үзүүлэлттэй чөлөөт худалдааны туршилтын бүс байх болно. Мөн манай улсыг Ази номхон далайн бүс нутагт хүчирхэгжиж эдийн засгийн даяаршилд нэгдэх чухал зөөгүүр болж Хятадын эдийн засгийн ахин хөгжихэд загварын үүрэг гүйцэтгэнэ.

Хамрах хүрээ

Үүнд хяналтын нэгдсэн бүс, “гурван боомт,гурван бүс” дөрвөн хяналтын тусгай бүс багтаж байгаа,нийтдээ 28.78 квадрат километртой.Түүний дотор Вэй Гао Чиао баталгаат бүс 10 квадрат километртой,Вэй Гао Чиао баталгаат ложистик терминал 1.03 квадрат километртой,Пүдун нисэх буудлын баталгаат нэгдсэн бүс 3.59 квадрат километртой,Ианшан баталгаат боомт бүс 14.16 квадрат километртой.Ианшан баталгаат боомт бүсийн дотор эх газрын талбай 6.85 квадрат километртой,арлын талбай 7.31 квадрат километртой.

Үүрэг роль (зургаан бүс)

нэг.олон улсын хөрөнгө оруулалтын журмын туршилтын бүс,хөрөнгө оруулалтын салбар
хоёр.үйлчилгээний худалдааны инновацийн хөтлөгч бүс,шинэ хөгжиж байгаа үйлчилгээний худалдаа
гурав.оффшорын төрлийн үйлдвэрлэлийн системийн төвлөрөх бүс,санхүүгийн салбар
дөрөв.гадаадад хөрөнгө оруулалт хийхэд үзүүлэх үйлчилгээний хөтлөгч бүс,хөрөнгө оруулалтын салбар
тав.хяналтын хэлбэрийг сайжруулах тэргүүлэх бүс,захиргааны тогтолцоо
зургаа.төрийн удирдлагын инновацийн загварын бүс,захиргааны тогтолцоо

Тодорхой арга хэмжээ (таван салбар)

I. хөрөнгө оруулалтын салбар

- 1、 гадаадын хөрөнгө оруулалтад эрх тэгш хандахыг туршиж хэрэгжүүлэх.
- 2、 хориотой жагсаалт гэдэг менежментын загварыг байгуулахаар судалгаа хийх.
- 3、 гадаадад хөрөнгө оруулахад үйлчилгээ үзүүлэхийг дэмжих механизм бий болгох.

II. худалдааны салбар

- 1、 худалдааны хөгжлийн шинэ хэлбэрийн инноваци хийх.
- 2、 олон улсын далайн тээврийн хөгжлийн бодлогын инноваци хийх.

Тодорхой арга хэмжээ (таван салбар)

III. санхүүгийн салбар

- 1、 санхүүгийн өөрчлөлтийн инновацийг гүнзгийрүүлэх.
- 2、 гадаад валютын бодлогын орчинг сайжруулах.

IV. захиргааны хууль эрх зүйн салбар

- 1、 захиргааны удирдлагын механизмын өөрчлөлтийг гүнзгийрүүлэх.

V. хяналт, татварын салбар

- 1、 хяналтын загврын инноваци хийх.
- 2、 холбогдох татварын бодлого.

Хөрөнгө оруулалтын салбар——гадаадын хөрөнгө оруулалтад эрх тэгш хандах бодлогыг туршиж хэрэгжүүлэх

Гадаадын хөрөнгө оруулалтад эрх тэгш хандах бодлогын зарчмын дагуу юуны өмнө туршилтын бүсийн хэмжээнд гурван зөвшөөрөн оруулах шат дамжлагад өөрчлөлт оруулна.

Төслийг зөвшөөрөн оруулах шат

Гадаадын хөрөнгө оруулалттай компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах шат

Үйлдвэрлэл, бизнес эрхлэхийг бүртгүүлэх шат

Хөрөнгө оруулалтын салбар——хориотой жагсаалт гэдэг менежментын загварыг байгуулахаар судалгаа хийх

Манай улсын үйлчилгээний салбарын хөгжлийн шаардлага болон туршилтын бүсийн үүрэг рольд нийцүүлэн эхний шатанд зургаан үйлчилгээний салбарыг сонгон дотоод гадаадад нээлттэй байдлыг нэмэгдүүлж байна.

**санхүүгийн салбар агаарын тээврийн салбар бизнес худалдааны салбар
мэргэжлийн салбар соёлын салбар нийгэмийн салбар**

Хүчингүй болгосон нь:

эрхийн шаардлага, хувьцааны харьцааны хязгаар, үйл ажиллагаа явуулах хүрээ зэрэг хязгаар.

Хөрөнгө оруулалтын салбар——гадаадад хөрөнгө оруулахад үйлчилгээ үзүүлэхийг дэмжих механизм бий болгох

Хөрөнгө оруулахад үйлчилгээ үзүүлэхийг дэмжих механизмын инноваци хийж зах зээлийн үйл ажиллагааны механизмыг сайжруулан бүх төрлийн хөрөнгө оруулагчийг идэвхтэй, үр бүтээмжтэй ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэхээр судалгаа хийх.

гадаадад хөрөнгө оруулахын менежментыг өөрчлөх

гадаадад хөрөнгө оруулсны дараах менежментыг нэмэгдүүлэх

гадаадын хувьцааг эзэмшихэд хөрөнгө оруулахыг дэмжих

валютын бус хөрөнгөөр гадаадад хөрөнгө оруулахыг дэмжих

олон улсын заншлаар хувьцааг хуваах механизмыг дэмжих

Худалдааны салбар——худалдааны хөгжлийн хэлбэрийн инноваци хийх

**Худалдааны шинэ хэлбэр,үүргийг идэвхтэй бойжуулан технологи,
брэнд,чанар,үйлчилгээ гэсэн гол агуулгатай гадаад худалдааны өрсөлдөх
шинэ давуу талыг бий болгон дэлхийн худалдааны үнэ цэнийн хэлхээ
холбоонд манай улсын эзлэх байр суурийг хурдан дээшлүүлье.**

Үйлчилгээний худалдааг хөгжүүлэхийг дэмжих

Оффшорын худалдааг хөгжүүлэхийг дэмжих

Дотоод гадаад худалдааг нэгдмэл байдлаар хөгжүүлэх

худалдааны салбар——олон улсын далайн тээврийн хөгжлийн бодлогын инноваци хийхийг дэмжих

Вэй Гао Чиао боомт, Ианшан гүн усны боомт, Пүдун нисэх буудлын боомт зэрэг олон улсын зангилаа боомтын уялдах үүргийг идэвхтэй ашиглан олон улсын өрсөлдөх чадвартай далайн тээврийн хөгжлийн механизм болон үйл ажиллагааны загварыг бий болгохоор судалгаа хийх.

далайн тээврийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэхийг дэмжих

дамжин өнгөрөхийнхийг нийлүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэхийг дэмжих

“Хятадын Ианшан” усан онгоцыг бүртгэх туршилтын цэгийг сайжруулах

Санхүүгийн салбар——санхүүгийн өөрчлөлт,инновацийг гүнзгийрүүлэх

1.бүсийн доторх хөрөнгийн төслийн хязгаар хоригийг хүчингүй болгох

2.бүсийн дотор зээлийн хүүг зах зээлжүүлэх

3.RMB-ыг хил дамнан чөлөөтэй хэрэглэхийг бүх талаар урагшлуулах

4.Санхүүгийн үйлчилгээний салбарыг хувийн хэвшлийн хөрөнгө болон гадаадын хөрөнгөд бүрэн нээлттэй болгохын төлөө ажиллах

5.бүсийн дотор дэлхийд чиглэсэн арилжааны платформ байгуулахыг санхүүгийн захад зөвшөөрөх

6.зах зээл өөрөө бие даан арилжааны бүтээгдэхүүнийг гаргахыг дэмжих

7.Банкны картын байгууллагыг хил дамнан тооцоолох болон электрон арилжааны платформ байгуулахыг дэмжих

8.Хувьцааг захиалгаар арилжих байгууллагыг бүсийн дотор санхүүгийн үйлчилгээний нэгдсэн платформ байгуулахыг дэмжих

9. RMB-ыг хил дамнан давхар даатгуулах үйл ажиллагааг эрхлэхийг дэмжих,олон улсын даатгалын зах зээлийг бойжуулан хөгжүүлэх

10.Санхүүгийн өөрчлөлт,инновацийг Шанхайн олон улсын санхүүгийн төвийн бүтээн байгуулалттай уялдуулах механизмыг бий болгох

Санхүүгийн салбар——гадаад валютын бодлогын орчинг сайжруулах

- 1. дэлхийд чиглэсэн гадаад валютын менежментыг өөрчлөх туршилтын цэг байгуулан чөлөөт худалдааны туршилтын бүсэд нийцсэн гадаад валютын менежментын механизмыг бий болгон худалдаа,хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөхэд бүрэн хүрэх.**
- 2. гадаад дотоодын хоёр төрлийн нөөц,хоёр зах зээлийг бүрэн ашиглахыг компанийг дэмжих,хил дамнан санхүүжүүлэхийг чөлөөтэй болгох**
- 3. гадаад өрийн менежментын хэлбэрийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх,хил дамнан санхүүжүүлэхийг хөнгөвчлөхийг дэмжих**
- 4. хил дамнасан аж ахуйн нэгжийн толгой компанийн гадаад валютыг төвлөрүүлэн удирдах туршилтын цэгийг сайжруулан хил дамнасан аж ахуйн нэгжийг Шанхайд бүс нутгийн чанартай эсвэл дэлхийн чанартай хөрөнгийн удирдах төвийг байгуулахыг дэмжих**

Захиргааны хууль эрх зүйн салбар——захиргааны удирдлагын механизмын өөрчлөлтийг гүнзгийрүүлэх

Засгийн газрын үүрэг ролийг өөрчлөхийг хурдатган засгийн газрын удирдлагын

хэлбэрийн инноваци хийж шударга өрсөлдөх зах зээлийн орчинг бүрдүүлэх

1. нэг цонхоор хүлээн авч нэгтгэн батлах үйлчилгээний загвар бий болгох

2. зах зээлийн хяналтыг цогцоор тавих төвлөрэн нэгдсэн хууль гүйцэтгэх системийг

байгуулах

3. засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх

4. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг үр дүнтэй хамгаалах механизмыг сайжруулах

5. оюуны өмчийн маргааныг эвлэрүүлэн зуучлах, дэмжлэг үзүүлэх зэрэг олон

төрлийн шийдвэрлэх механизмыг байгуулах

Хяналт, татварын салбар — хяналтын загварын инноваци хийх

Гаалийн хяналтын механизм, загварыг өөрчлөн сайжруулах нь Шахайн баталгаат нэгдсэн бүсэд чөлөөт худалдааны туршилтын бүс байгуулах гол агуулга, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарыг илүү нээлттэй болгох урьдчилсан нөхцөл мөн.

Үндсэн зорилт:

Анхны шатанд шат дараалан бүрэн нээлттэй болох

Хоёрдугаар шатанд аюулгүй, өндөр чадамжтай удирдах

Бүсийн дотор бараа бүтээгдэхүүний чөлөөтэй эргэлт

Хяналт татварын салбар——холбогдох татварын бодлого

Үүрэг сайжруулахыг чиглэл болгон татварын тогтолцооны өөрчлөлтийн туршилт хийж холбогдох татварын бодлогыг эхлээд өөрчлөн дотоодын бусад татварын журмын өөрчлөлттэй уялдуулж хөрөнгө оруулалт,инновацийг дэмжих бодлогын орчинг бүрдүүлэхийн төлөө чармайн ажиллах. Үндсэн зорилт:

Хөрөнгө оруулахыг дэмжих татварын бодлого хэрэгжүүлэх

Худалдааг дэмжих татварын бодлого хэрэгжүүлэх

Гаалийн хяналтын загварт нийцсэн татварын бодлого хэрэгжүүлэх

Дөрөв. Чөлөөт худалдааны бүс бидний амьдралд юу авчирч ирэх вэ

- Чөлөөт худалдааны бүсэд хэрэгжүүлж байгаа олон нээлттэй бодлого болон инновацийн дотор ихээхэн төсөөлөлтэй салбар бол санхүүгийн нээлттэй байдал.



- Зээлийг хүүг зах зээлжүүлэх
- валютыг чөлөөтэй хөрвөх
- Санхүүгийн салбарыг гадаадад нээлттэй болох
- Санхүүгийн бүтээгдэхүүний инноваци
- Оффшор санхүүгийн үйлчилгээ

Чөлөөт худалдааны бүсийн ач холбогдол

Чөлөөт худалдааны бүсийн гол ач холбогдол :

- ① бараа бүтээгдэхүүнийг төвлөрүүлэн хуваах төвийн статусыг ашиглан экспортын худалдаа болон дамжин өнгөрөх худалдааг нэмэгдүүлж улс болон бүс нутгийн олон улсын худалдаанд эзлэх байр суурийг дээшлүүлэн гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх.**
- ② гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаадын дэвшилтэт технологи, менежментын туршлагыг нэвтрүүлэхэд эерэг нөлөөтэй.**
- ③ ажлын байрыг нэмэгдүүлэхэд тустай.**
- ④ боомтыг хөгжүүлэх, тус улсын зам тээврийн салбарыг хөгжүүлэх, хил орчмын нутгийн эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх.**

Чөлөөт худалдааны бүсийн ач холбогдол

- **FTA бүс нутгийн эдийн засагт дараах хоёр янзаар нөлөөг үзүүлнэ :**

Шууд нөлөө : бүс нутгийн доторх гишүүн улс орнуудын хооронд гаалийн татвараас чөлөөлөх, худалдааны хэмжээний хязгаарлалтыг хүчингүй болгосны улмаас гишүүн улс орнуудын худалдааны хөгжилд шууд үзүүлсэн нөлөө.

Дам нөлөө : FTA-ыг байгуулсны дараа бүс нутгийн хэмжээнд үйлдвэрлэлийн бүтээмж дээшилсэн, хөрөнгийн хуримтлалт нэмэгдснээс болж гишүүн улс орнуудын эдийн засгийн өсөлт нэмэгдэхэд хүргэсэн дам нөлөө.

- **Энэ хоёр нөлөөг бас статик үр дүн, динамик үр дүн гэж тус бүр нэрлэдэг.**

Статик үр дүн

Статик үр дүнгийн дотор худалдааг бүтээх нөлөө болон худалдааг

шилжүүлэх нөлөө нь төлөөлөх шинж чанартай.Худалдааг бүтээх нөлөө гэж бүс нутгийн доторх гишүүний хооронд арилжааны өртөг буурсан,худалдааны хязгаарлалт хүчингүй болсноос тус улсын өндөр өртөгтэй бүтээгдэхүүнийг бүс нутгийн доторх бусад гишүүний бага өртөгтэй бүтээгдэхүүнээр орлуулах,урьд нь нөгөө талын тоо хэмжээ,өндөр гаалийн татваар хязгаарлагдаж байсан тус улсын бага өртөгтэй бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэхэд хүргэж бүс нутгийн доторх экспортлогч импортлогч хоёр талуудад илүү олон худалдааны боломж,эдийн засгийн үр ашиг олсон үйл явдлыг хэлнэ.Худалдааг шилжүүлэх нөлөө гэж урьд нь бүс нутгийн гаднах улс орнуудтой хийсэн худалдааг бүс нутгийн доторх арилжааны өртөг буурснаас болж бүс нутгийн гишүүний хоорондох худалдаагаар орлуулж магадгүйг хэлнэ.

Динамик үр дүн

Динамик үр дүнгийн дотор зах зээлийг өргөжүүлэх нөлөө, өрсөлдөөнийг

бий болгох нөлөө голчлон орж байгаа. Эхнийх нь худалдааны хэмжээ

нэмэгдэхийн хэрээр үйлдвэрлэл, эргэлтийн хэмжээний үр нөлөөг бий болгон

үйлдвэрлэлийг төвлөрүүлэх үр дүнд хүрнэ. Дараагийнх нь бүс нутгийн

нэгдсэн зах зээл бий болсноор бүс нутгийн монополийн салбарын

өрсөлдөөнийг ширүүсгэж үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлнэ. **Худалдааг**

бүтээх нөлөө, зах зээлийг өргөжүүлэх нөлөө, өрсөлдөөнийг бий болгох нөлөө

олон эерэг нөлөө үзүүлэх болно, гэвч худалдааг шилжүүлэх нөлөө эсрэг нөлөө

үзүүлж магадгүй, яагаад гэхлээр бүс нутгийн доогуур бүтээмжтэй

бүтээгдэхүүн гишүүн бусын өндөр бүтээмжтэй бүтээгдэхүүнийг орлож

магадгүй.

➤ Шанхайн чөлөөт худалдааны бүсийн ирээдүй ямар байх бол? хүний сэтгэлийг хөдөлгөж чадах үү



Хонконгийн улсын санхүүгийн төв

Шанхай өөр нэг
Хонконг болж чадах үү



Шанхайн ЛужиаЗуй

Эсвэл Шанхай Хонконгийг орлох уу?

Олон улсын санхүүгийн төвийн онцлог :

- 1、 дэлхийд хандсан санхүүгийн байгууллагатай ;
- 2、 гадаадын хөрөнгө чөлөөтэй эргэж болно ;
- 3、 их хэмжээний арилжаа хамрагдаж байгаа.

Хонконг

1978 оноос хойш

Хятадын өөрчлөлт, нээлттэй бодлого

Дотоодын компанийг санхүүжүүлэх

Наяад онуудад

Боловсон хүчин сургах

Санхүүгийн хямралаас туршлага сургамж сурах

одоо

Дэлхийн дээр дээгүүр жагсаж байгаа

(олон улсын бүс нутгийн санхүүгийн төв)

Хонконг

Амжилтад хүрсэн хүчин зүйл

Чөлөөт зах дээл

Боловсон хүчин

Таатай хууль эрх зүйн нөхцөл болон засгийн газрын бодлого

Авилгагүй ,өндөр үр бүтээмжтэй засгийн газар

мэдээлэл,технологийн эргэлт

Хялбар татварын тариф

бусад

Хонконг

- Дэлхийн хамгийн чөлөөтэй эдийн засгийн систем. Дэс дараалан тасралтгүй 12 жил Уламжлалт сангаас дэлхийн хамгийн чөлөөтэй эдийн засгийн системээр шалгаруулав. (1.28 оноотой).

Бүрэн боловсон чөлөөт эдийн засгийн систем

- 1. эдийн засгийг зах зээл давамгайлан хөгжүүлэх
- 2. засгийн газраас хөндлөнгөөс оролцохгүй бодлого

сангийн газрын дарга Тан Ин-ниан : Засгийн газраас Хонконгт чөлөөтэй зэх зээлийн эдийн засгийг тууштай хөгжүүлж хувийн хэвшлийнхэнд илүү өргөн хөгжих боломж олгохын төлөө ажиллах болно.

Ерөнхий захирагч Зэн Ин-чуан: том зах зээл, бага засгийн газрын зарчимыг хатуу барих, зах зээл давамгайлах, засгийн газар дэмжих гэдэг чөлөөт эдийн засгийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх.

- 3. хөрөнгө оруулалтын төрөл их олон



Хонконг

Дотор газрын эдийн засгийг түшиглэн хөгжих

Төвөөс дэмжих

Дэлхийн санхүүгийн байгууллагыг татан төвлөрүүлэх

Санхүүгийн боловсон хүчин бэлтгэхийг хурдатгах

Олон улсын санхүүгийн төв болохыг хурдатгах

Эдийн засгийн арга хэмжээ

- зах зээлд засгийн газрын оролцоог багасгах
- зах зээл давамгайлан ажиллахад аажим дасан зохицох
- «орчин үеийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэхийг эрчимжүүлэх

Шанхайн хөтөлбөр»

“голыг олох, бодлогыг гаргах, босгыг багасгах, субъектыг хүчирхэгжүүлэх”

Хөрөнгө оруулалтын салбарын хязгаар (гадаадын хөрөнгө)

- — худалдааны санхүүгийн салбар
- — радио, коногийн салбар
- — эрчим хүчний үйлдвэрлэл, хотын олон нийтийн үйлчилгээний салбар

Засгийн газрын бодлого, хангамж болон хөрөнгө оруулагчийн итгэл

Хятадын талаас:

Хятадын төрийн бодлогын тодорхойгүй байдал

Гадаадын санхүүгийн байгууллага болон гадаадын хөрөнгө оруулагч санаа зовж орохгүй

Хувьцааны өсөлт, уналтыг засгийн газар бодлогоор бүрэн удирдах

Хууль эрх зүй боловсронгуй биш, зах зээлийн эдийн засгийн шаардлага болон олон улсын дүрэмд нийцэхгүй

➤ Богино хугацаанд Шанхайг өөр нэг Хонконг болгох нь бодит бус



Хонконгийн олон
улсын санхүүгийн төв

- Ойрын хэдэн жилд Хонконгийн эдийн засгийн өсөлт тээглээтэй тулгарав.
- Төвийн бодлогын дэмжлэгээр хөгжиж байгаа.
- Ингэсэн ч гэсэн Хонконгийн санхүүгийн туршлага, нээлттэй орчноос Шанхай бас зөрүүтэй байна.

- Санхүүгийн нээлт өргөн боломжтой байгаа ч хүнд бэрхшээлтэй бас тулгарч байгаа.




Шанхайн ЛужиаЗуй

- Төв засгийн газар болон орон нутгийн засгийн газрын ихээхэн дэмжлэг авсан ч гэсэн нэг хоёр бодлогоор санхүүгийн нээлтэд хүрэхгүй.
- Одоо тулгарч байгаа асуудал,одоо мөрдөж байгаа бодлогоор RMB-ыг чөлөөт худалдааны бүсийн дотор чөлөөтэй хөрвөх боломжтой.Тэгвэл цаашид чөлөөт худалдааны бүс хулуун мөнгө болон нууц банкны диваажин болох уу

➤ Хонконгтой харьцуулахад Шанхай дотоодод бас ширүүн өрсөлдөөнтэй тулгарч байгаа.

Харин Шанхайн чөлөөт худалдааны бүс бол шууд төвд тайлагнадаг.

Дугаарлагчид чөлөөт худалдааны бүсийг төлөвлөхэд бэлэн байна



Тианжин ШанМэн Хэнчин Наншаа Чианхай Цончин

Эцэст нь дүгнэхэд



Орон сууцны үнэ өсөх
хандлагатай юу

- Шанхайн чөлөөт худалдааны бүс лав л нэмэх үйлдэл, харин хасах үйлдэл бишээ
- Хамгийн ашигтай нь цаашид шопин хийхэд амархан болжээ, хуурай сүүг Хонконгоос авах хэрэггүй боллоо
- Харин Шанхайг богино хугацаанд Хонконг гүйцэж орлох боломж хомс
- Чөлөөт худалдааны бүс бол Ли Кэцян ерөнхий сайдын том туршилтын үйлдэл, Шанхай бол түрүүчийн цэрэг, олон нийтийн хүслээр чухал үүрэг гүйцэтгэж байгаа.

тав.чөлөөт худалдааны бүсийн ирээдүй

олон улсын их хэмжээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн ирээдүй

—таван чиглэлийн өөрчлөлт



олон улсын их хэмжээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн ирээдүй

—үйлдвэрлэгчийн боломж

үйлдвэрлэгч

Барааны үнэ	Цар хүрээ, менежмент	Хөрөнгө оруулалт, санхүүжүүлэлтын орчин	Татварын бодлого
<ul style="list-style-type: none">• мэдээлэл авах шугам нэмэгдэв• барааны үнийн хэлбэлзэлийг дөнгөх чадвар дээшлэв.	<ul style="list-style-type: none">• Барааны эргэлтийн цаг богиносож үйлдвэрлэлийн өртөг буурав.• барааг борлуулах шугам өргөжиж хөрөнгийн эргэлт нэмэгдэв.	<ul style="list-style-type: none">• санхүүжүүлэлтын шугам тэлэгдэв.• хөрөнгө оруулж хувийн хэвшлийн банк байгуулж болно.	<ul style="list-style-type: none">• компани машин механизм, тоног төхөөрөмж импортлоход татвараас чөлөөлдөг.• их хэмжээний барааг импортлох татварын орчин сайжирах хүлээлттэй байна.

Олон улсын их хэмжээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн ирээдүй

—худалдаалагчийн боломж

худалдаалагч

Барааны үнэ	Цар хүрээ, менежмент	Хөрөнгө оруулалт, санхүүжилтын орчин
<ul style="list-style-type: none">• мэдээлэл авах шугам нэмэгдэв• барааны үнийн хэлбэлзэлийг дөнгөх чадвар дээшлэв.	<ul style="list-style-type: none">• худалдааны хэмжээ төрөл нэмэгдэв.• дамжин өнгөрөхийнхийг нийлүүлэх салбар хөгжиж тээврийн өртөг буурав.• арилжааны мэдээлэл ил тод болж худалдааны өрсөлдөөн ширүүсэх болно.• дам худалдаанаас ашиг олох боломж хумигдав.	<ul style="list-style-type: none">• агуулах хуудсаар барьцаалан санхүүжилт авах төрөл нэмэгдэв.• агуулах хуудсаар барьцаалан санхүүжилт авах зэх зээлд оролцогч олшров.• компанийн санхүүжүүлэлтын шугам тэлэгдэв.• хөрөнгө оруулж хувийн хэвшлийн банк байгуулж болно.

олон улсын их хэмжээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн ирээдүй
—гуравдагч этгээдийн боломж

Гуравдагч компани,байгууллага

Барааны үнэ	Цар хүрээ,менежмент	Татварын бодлого	Хяналтын арга хэмжээ
<ul style="list-style-type: none">• далайн тээврийн үнийн индексийн деривативын арилжаа хөгжиж ложистикийн компанийг эрсдлээс хамгаалах чадвар дээшлэх болно.	<ul style="list-style-type: none">•Платформын чанартай компани (Жишээлбэл И-Мао) бүсийн гаднах их хэмжээний нөөц баялагын хуваарилалтад оролцох боломж нэмэгдэв.•Нийлүүлээд тээвэрлэх нь ложистикийн өртөгийг бууруулж байгаа.• Далайн орчимд дайж тээвэрлэх нь ложистикийн компанийн үйл ажиллагааны цар хүрээг тэлж байгаа.	<ul style="list-style-type: none">• Хятадын хөрөнгө оруулалттай гадаадын харьяат олон улсын далайн тээврийн усан онгоц боомтод гаалийн татвараас чөлөөлж түлш хангуулах боломжтой.•боомтод ачигдвал татвар буцаах туршилтын цэг өргөжиж тээврийн өртөг буурах болно.• далайн орчмын ачааны тээврийн болон дамжин өнгөрөх худалдааны хэмжээ нэмэгдэв.	<ul style="list-style-type: none">• барааг хянах арга хэмжээ чангатгаж агуулахын хуудсаар давхар барьцаалагдах боломжийг хумив.

худалдааны шинэ хэлбэр — толгой компанийн эдийн засгийг хөгжүүлэх

Компанийн ази номхон далайн бүс нутгийн толгой компанийн үйл ажиллагааны төв



Санхүүгийн үйлчилгээ

худалдаа

ДОТООД

ДЭЛХИЙ

Гадаад дотоодын худалдааны интеграци

ЛОЖИСТИК

ТООЦОО

Олон улсын худалдааны тооцооны туршилтыг гүнзгийрүүлэх

Гүйвүүлэн хөрвөх эрсдлээс хамгаалах

банк



Шинэ тооцооны хэлбэрийг өргөжүүлэх
зээлийн үйлчилгээг өргөжүүлэх

Хөрөнгө татах

Хил дамнан төлөх

санхүүжүүлэлт

Валютыг шууд хэрэглэх



Худалдааны шинэ хэлбэр——боомтын үйл ажиллагааны загварыг ахиулах



худалдааны шинэ хэлбэр — олон улсын стандартын дагуу далайн тээврийг удирдах



Далайн тээврийн санхүү
Далайн тээврийн үнийн индексийн үйл
ажиллагааг хөгжүүлэх

**ХуйДэЛи
хөрөнгө
оруулалтын
менежмент**

Олон улсын усан онгоцын тээвэр

**Дорнод олон
улсын ложистик**


Олон улсын усан онгоцын менежмент
Олон улсын усан онгоцыг бүртгэх журам хэрэгжүүлэх
Олон улсын усан онгоцыг бүртгэхийг хялбаршуулах

**Хунши олон
улсын худалдаа**

Олон улсын далайн тээврийн эдийн засаг

**Хятад давс олон
улсын ложистик**

худалдааны шинэ хэлбэр — далайн тээврийн үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх



илүү чөлөөтэй санхүүгийн зах зээл

Санхүүгийн зах зээл

Санхүүгийн үйлчилгээний
салбар нээлттэй болох

Хувийн хэвшил, гадаад
хөрөнгө хамтран хөрөнгө
оруулалттай банк
байгуулж болно

Олон улсад хандсан арилжааны
платформ

Барааны фьючерсийн
арилжаанд оролцохыг
гадаадын компанийг
зөвшөөрөх

Хөрөнгийн дансыг чөлөөтэй
солилцох

RMB-ыг чөлөөтэй
хөрвөх


хүүг зах зээлжүүлэх

Хүүг захиралтаас
чөлөөлөх

илүү чөлөөтэй санхүүгийн зах зээл

— дэлхийд хандсан арилжааны платформ

Дэлхийн деривативын арилжаа жилийн дундаж нийлмэл өсөлтийн хэмжээ




илүү чөлөөтэй санхүүгийн зах зээл

— дэлхийд хандсан арилжааны платформ


Ази ,номхон далайн бүс нутаг фьючерс,опцион арилжааны гуравны нэгийг эзэлж байгаа.

Дэлхийн деривативын арилжааны бүс нутгаар



■ Хойд америк ■ Ази номхон далай ■ Ойрхи дорнод

Дэлхийн фьючерс,опцион арилжааны харьцуулалт (тэрбум)



■ фьючерс ■ опцион

Ази номхон далайн бүс нутгийн фьючерсын арилжааны хэмжээ дэлхийн гуравны нэгийг эзлэв.Хятад бол их хэмжээний барааны том хэрэглэгч учраас чөлөөт худалдааны бүсэд фьючерсын арилжааны агуулахыг байгуулах нь гадаадын биржийг Хятадад татан оруулж Хятадын санхүүгийн зах зээлийг олон улстай уялдахад тустай.

ИЛҮҮ ЧӨЛӨӨТЭЙ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ


— хөрөнгийн данс бүрэн нээлттэй болох

Эхний аравт оров. Валют ам.доллараар тооцох арилжааны хэмжээгээр жагсаав.



RMB дэлхийн хамгийн их арилжаалагддаг эхний арван валютын жагсаалтад оров.

日均交易额份额*及排名



*鉴于交易涉及两种货币, 日均交易额总体份额为200%。

数据来源: 国际清算银行

《华尔街日报》

Хөрөнгийн дансыг бүрэн нээлттэй болгох нь RMB-аар хил дамнан тооцоо хийх цар хүрээг өргөжүүлж хил дамнан санхүүжилт чөлөөтэй авах боломж нээгдэнэ.


— хүүг зах зээлжүүлэх

Төв банкны бодлогын хүүгээс бага хүүтэй зээлийн хувь



数据来源：wind 易贸研究中心整理

Төв банкнаас хадгаламж, зээлийн хүүд тавигдаж байгаа хязгаарыг сулруулж хүүгийн зөрүүг хамгаалахаас чөлөөлж байгаа.



Хүүг зах зээлжүүлэх нь хөрөнгийг ашиглах өртгийг зах зээл тогтоох механизмыг сайжруулах болно. Зах зээлийн механизм хөрөнгийг ашиглах өртгийг тогтоодог болно. Хадгаламжийн хүүг барихгүй нь чухал.

НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖАГСААЛТ — ХУВИЙН ХЭВШЛИЙН БАНК

Хамтран хөрөнгө оруулалттай банк байгуулах (хязгаартай гэрчилгээ)


Хязгаартай банк байгуулах нь Хятадын аж ахуйн нэгж гадаадын хөрөнгөтэй хамтарч гадаадын санхүүгийн зах зээлийг нээхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Хориотой жагсаалтын дагуу чөлөөт худалдааны бүсийн гадаад дотоодын хөрөнгө оруулалттай санхүүгийн байгууллага 49 хувиас дээш хувьцааг эзэмшиж болохгүйг тогтоов.



Гадаадын хөрөнгө оруулалттай банк


татвар төлсний дараах ашиг (зуун сая юань)



Төрийн өмчтэй бизнесийн банк гадаадын хөрөнгө оруулалттай банкны ашгийн харьцаа



— 2008 — 2009 — 2010 — 2011 — 2012



НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖАГСААЛТ—усан ОНГОЦНЫ ТЭЭВЭР

- Дамжин өнгөрөхийнхийг нийлүүлэх салбарыг хөгжүүлэх

Шанхай боомт ачих,буулгах үйл ажиллагаанаас задлах угсрах чадвартай төвлөрүүлэн хуваах төвд шилжсэн нь тээврийн өртөгийг ихээхэн бууруулав.

- Хятадын компанийн эзэмшиж байгаа эсвэл давамгайлсан хувьцаатайгаар эзэмшиж байгаа таван одтой бус онгоцыг зөвшөөрөх нь

Хятадын хөрөнгө оруулалттай гадаадын харьяаттай олон улсын усан онгоцонд чөлөөт худалдааны бүсээс таван одтой бус онгоцын статус олгож гаалийн татвараас чөлөөлж боомтод түлшээр хангуулах боломжтой.


- Дотоодын далайн боомт,Шахайн боомтын хоорондох гадаад худалдааны экс-импортын чингэлэгээр дайж тээвэрлэх үйл ажиллагааг туршиж явуулах

Далайн боомтуудын хооронд гадаад худалдааны ачаатай чингэлэгийг дотоодод тээвэрлэхэд зөвхөн Хятадын харьяаттай онгоцыг дамжин өнгөрөхийг зөвшөөрөх нь

- Хятадын хөрөнгө оруулалттай гадаадын далбаатай онгоцод үзүүлж байгаа татварын хөнгөлөлын бодлогыг ашиглаж шаардлагад нийцсэн онгоцыг Шангайд бүртгүүлэхийг дэмжих

Онгоцны бүртгэл нээлттэй улсад бүртгэж тус улсын харьяаттай болж (Жишээлбэл Хятад) тус улсын далбааг өлгөж байгаа онгоцыг хэлж байна.

"НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖАГСААЛТ" — бусад



Бизнес худалдааны үйлчилгээ

- Нэмүү өртөгтэй харилцаа холбоо
- Тоглоомын машины борлуулалт, үйлчилгээ

Соёлын үйлчилгээ

- Тоглолтын зуучлалт
- Тоглолтын талбай

Нийгмийн үйлчилгээ

- Боловсролын сургалт, мэргэжлийн сургалт
- Эмчилгээний үйлчилгээ

захиргааны удирдлагын загварын өөрчлөлт

Үйлдлийн
өмнө
зөвшөөрөл
олгох

Үйлдлийн
дунд
үйлдлийн
дараах
хяналт

Гарааны бизнес хийхэд босгогүй

Нэг цонхоор хүлээн авах

Хуулийг гүйцэтгэх
хяналтын нэгдсэн систем

Мэдээллийг ил зарлах,
журамлах

Татвараар хөрөнгө оруулалтыг дэмжих

Аж ахуйн нэгжийн орлогын татвар 15% ?



Хөрөнгийн үнэлгээ нэмэгдэх
Орлогын татварыг хэсэгчлэн
төлөх ?

Хэлэлцээд батлав

хамрах хүрээ : газар мэт үнэ нь
нэмэгдсэн, харин бэлэн мөнгөний урсгал
бий болгохгүй хөрөнгө.

ашигтай тал : барилгын
компани, паркийг удирдах компани

Хувьцаагаар идэвхжүүлэх
Орлогын татварыг
хэсэгчлэн төлөх ?

Хэлэлцээд батлав

хамрах хүрээ : компанийн хувьцаагаар
идэвхжүүлэх хувь хүн

ашигтай тал : өндөр технологийн
компани, хувийн хэвшлийн компани

Татвараар худалдааг хөгжүүлэх

санхүүгийн түрээс экспортын татвар буцаах туршилтын цэгийн хүрээг өргөжүүлэх——
“Тианжин туршлага” (2010 оны 4-р сарын 1-ний өдөр)



хамрах хүрээ : сул жин 25 тонноос дээш, дотоодын авиа компанид түрээсээр хэрэглүүлж байгаа нисэх онгоц.

ашигтай тал : дотоодын нисэх онгоцны түрээсийн компани гадаадад гарахад дэмжлэг болно.

Үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн чанартай үйлчилгээний этгээд машин механизм, тоног төхөөрөмж импортлоход татвараас чөлөөлдөг



хамрах хүрээ : үйлдвэрлэлийн, үйлдвэрлэлийн чанартай үйлчилгээний компани хэрэгцээтэй машин механизм, тоног төхөөрөмж импортлоход

ашигтай тал : дээрх компанийн элэгдэлийн өртөг буурах болно.

Ачигдах боомтын татвар буцаах туршилтын цэгийн бодлогыг сайжруулах—— “Ианшан боомтын туршлага” (2012 оны 8-р сарын 1-ний өдөр)



хамрах хүрээ : туршилтын хүрээг өргөжүүлэхээр судалж байна.

ашигтай тал : экспортын компанийн хөрөнгийн эргэлт хурдатгана.

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэх, хянах



- хөхиүлэн дэмжих бүлэг, хязгаарлах бүлэг, хориглох бүлэг

“гадаадын хөрөнгийн гурван хууль”

- хуулиар хориглоогүй бол эрхэлж болно гэсэн үг
- тус улсын иргэдтэй адил боломжийг хөрөнгө оруулалтын өмнө олгох

**Хориотой жагсаалт
Гадаадын хөрөнгө
оруулалтад эрх тэгш хандах**

- TPP, TTIP хэлэлцээг хийх бэлтгэл хангах

**Олон улсын стандартад
нийцсэн гадаадын
хөрөнгийн менежментын
тухай хууль**